

## Дублины дүрмийн тухай

Орогнол хүсэгч цагаачлагчийн өргөдлийг аль улс орон хүлээн авч, шалган хэлэлцэж, шийдэх талаар тухайн өргөдөл гаргагч нь өөрөө сонгох эрхгүй. Дублины дүрэм нь доор дурдсан Европын Холбооны гишүүн орнуудаас гадна Норвеги, Исланд зэрэг улс орнуудад мөрдөгддөг. Дублины дүрмээр дээрх улс орнууд орогногч цагаачдийн өргөдлийг хэлэлцэх шийдвэрлэх орныг дүрэмчлэн зохицуулдаг. Та эдгээр улс орнуудын зөвхөн аль нэг орноор өөрийнхөө өргөдлийг шалгуулж шийдүүлэх эрхтэй.

### Орогнол хүсэгчийн өргөдлийг аль орон хэлэлцэх вэ?

Хэрвээ та Швэд улсад цагаачилж, орогнохыг хүсэж, түүнчлэн тус улсад хандаж, өргөдлөө гаргаж өгсөн ч таны хэргийг Швэд улс хэлэлцэж, шийднэ гэсэн баталгаа байхгүй. Тиймээс Дублины дүрэмд нэгдсэн орнуудын аль нэг орон тухайн өргөдлийг хүлээн авч, хянан хэлэлцэх хариуцлагатай орон байж болно. Энэ тохиолдолд тухайн орогнол хүсэгч цагаачлагч нь хэргийг хэлэлцэн шийдвэрлэх тус орон руу өөрийн биеэр явж очих буюу хүргэгдэх шаардлагатай юм. Дараах нөхцөлүүдэд өргөдлийг өөр орон хэлэлцэх болно Үүнд:

- Дублины дүрэмд нэгдсэн өөр оронд орох виз, оршин суух зөвшөөрөлтэй
- Дублины дүрэмд нэгдсэн аль нэг оронд хууль бусаар нэвтэрсэн
- Дублины дүрэмд нэгдсэн орнуудын аль нэгэнд цагаачлах өргөдлөө аль хэдийнэ гаргасан
- Гэр бүлийн гишүүний хэн нэг нь Европын Холбооны гишүүн орнуудын аль нэг оронд оршин суух зөвшөөрлийг авсан тохиолдолд

тус орон нь тухайн цагаачлал хүсэгчийн өргөдлийг хэлэлцэн шийдэж болно.

### Бүртгэл мэдээлэлд өгөгдсөн хурууны хээг шалгах

Цагаачлалын алба нь 14-өөс дээш насны бүх орогнол цагаачлал хүсэгчдийн хурууны хээг авч, "Евродак" бүртгэл мэдээлэлд оруулан шалгадаг. Энэхүү бүртгэл мэдээллээс тухайн цагаачлал хүсэгчийн хурууны хээ аль нэг оронд бүртгэгдсэн эсэхийг тодруулан шүүн гаргаж ирэх болно.

### Цагаачлалын өргөдлийг өөр орон

хэлэлцэх тохиолдолд Цагаачлах тухай өргөдлөө өгсөн гадаад иргэний өргөдлийг Европын Холбооны өөр нэг орон хэлэлцэх болсон тохиолдолд Цагаачлалын албанаас цагаачлал хүсэгчийг тухайн оронд явуулах шийдвэрийг гаргана. Тус шийдвэрийн дагуу Швэд орноос явахыг хүсэхгүй тохиолдолд албадан гаргах хэмжээг авах эрхтэй.

### Шийдвэрийг давж заалдах

Цагаачлал хүсэгчийн өргөдлийг өөр улс оронд хэлэлцүүлэх тухай шийдвэр гарсан тохиолдолд тухайн өргөдөл гаргагч нь Цагаачлалын албаны шийдвэрийг давж заалдах эрхтэй. Энэ тохиолдолд Цагаачлалын албанаас цагаачлал хүсэгчийн цагаачлах өргөдөл гаргах болсон шалтгаан, хүсэлтийг хэлэлцэхгүй, зөвхөн аль улс оронд түүний өргөдлийг хүлээн авч хэлэлцүүлэх талаарх шийдвэрээ дахин хянаж үзэх болно. Давж заалдсан нөхцөлд ч Швэд улсаас тус улс руу явах шаардлагатай.

**...Дублины дүрэмд нэгдсэн орнууд**

Европын Холбооны гишүүн орнууд болох  
Бельги, Болгар, Кипр, Дани, Естони, Финланд,  
Франц, Грек, Ирланд, Итали, Латви, Литуани,  
Луксэмбург, Малта, Нидэрланд, Польш, ортугал,  
Румен, Словак, Словени, Испани, Их Британи,  
Швед, Чех, Герман, Унгар болон Австри.  
Түүнчлэн Норвеги болон Исланд тусгай гэрээний  
дагуу Дублины дүрэмд нэгдэн орсон орнууд юм.

**...Евродак**

Дээр дурдсан Европын Холбооны бүх улс  
орнууд Евродак гэгдэх электрон цахим бүртгэл  
мэдээлэлд холбогдсон байдаг. Мөн түүнчлэн  
Норвеги болон Исланд тусгай гэрээгээр тус  
цахим бүртгэлд мэдээлэлд холбогдсон байдаг.